

Дундговь - Асуудал-Шийдэр фейсбүүк группт 10 сарын 17-с 11 сарын 05 хүртэлх

хугацаанд ирсэн санал, гомдол

2024-11-06

№	Асуудал	Санал, хүсэлт ирүүлсэн огноо	Хариуцах байгууллага, сум	Шийдвэрлэж, хариу өгөх хугацаа
1.	<p>Эрдэнэдалай Сумын төв: 1. 2 км замын асуудал, 2. Ундны усны асуудал, 3. Сумын төвийн инженерийн шугам сүлжээ, цэвэр бохир усны шугам, 4. 96 айлын орон сууц / залуучуудыг амьдрахад таатай орчин бүрдүүлэх/, Малчдын өмнө тулгамдаж буй асуудал, 5. Өнгөт, Цавчир, Цагаановоо, Тэнгэлэг багуудад үүрэн холбооны сүлжээтэй болох, интернет хэрэглэх, 6. Байгаль орчны асуудал /Хайгуулийн лиценз , Шонхор, нохой, муур, хогны , огтоно гм/</p>	2024.10.17	<p>Эрдэнэдалай сум, ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг</p>	
2.	<p>Өнгөрсөн жилийн 10-р сард манай зарим байгууллагын удирдлага 10 гаруй хүн УИХ-ын гишүүн Б.Саранчимэгийн ажлын айлчлалын бүрэлдэхүүнд орж БНХАУ-ын Ниншя муж руу яваад ирсэн. Ниншя муж нь элсэн цөлийн 90 гаруй хувийг ногооруулсан гэдгээрээ онцлогтой муж юм. Хятадын хамгийн хөгжил дорой муж байсныг Ши Жинпин дарга нь 1999 онд зэргэлдээ Фужиан мужийн дарга байхаасаа анхааралдаа авч, одоог хүртэл хаялгүй хөгжүүлж ирсэн юм билээ. Өөрсдийн хэд хэдэн онцлог боломжуудад тулгуурлан хөгжсөн маш баялаг туршлагатай газар. Манай аймагтай холбоо харилцаа тогтоох талаар яригдсан. Энэ харилцааг лавшруулаад, ялангуяа Дундговийн ногоон хөгжлийн асуудал дээр хамтраад, туслалцаа аваад явбал энгийн бөгөөд үр дүнтэй арга туршлагауд зөндөө байна гэж харсан.</p>	2024.10.17	ТЗУХ ХБТХОХ	
3.	<p>Дундговь аймгийн төвөөс 186 км алслагдсан мөн Монгол Улсын алслагдмал сумдад багтдаг Өндөршил сумын нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал Сумын төв:1. Сумын төвийн инженерийн шугам сүлжээ, халаалтын шугам, цэвэр бохир усны шугам 2. Цахилгаан эрчим хүчний шугамын хүчин чадал нэмэгдүүлэх, өргөтгөх 3. 24 айлын орон сууц 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдахаар шав тавьсан соёл спортын цогцолборыг эхлүүлж ашиглалтад авах 5. Эрүүл мэндийн төвийн барилга</p>	2024.10.17	ХБТХОХ	

	<p>6. Малчдын өмнө тулгамдаж буй асуудал шийдэл</p> <p>1. Сумын газар нутаг дээр 100 хувь үүрэн холбооны сүлжээтэй болох, интернет хэрэглэх (2000, 2001, 2009, 2017, 2018, 2020, 2021 оны зуд байгаль цаг уурын хүндрэлд Өндөршил сумын нутагт өөрийн аймгийн бүх сумдаас малчид, оторчид болон бусад 4 аймгийн мал сүргээс отроор өвөлжиж хор хохирол арай багатай онд мэнд орж байсан. Өндөршил сум Дундговийн мал сүргийг өмөг түшиг болдог газар нутаг учир сүлжээ харилцаа холбоог Дундговь даяар үр шимийг нь хүртэнэ).</p> <p>2. 10000 боодол өвс багтах өвс, тэжээлийн аюулгүй найдвартай агуулахтай болох</p> <p>3. Дорноговь аймгийн Даланжаргалан, Айраг, Сайхандулаан, Мандах сумдын нутаг дэвсгэрт 3-4 үеэрээ нутаглаж ирсэн малчдын бэлчээр нутгийн маргааныг эв зүйгээр шийдвэрлэх</p>			
4.	Дундговьд ирээд 10 жил болоход хүүхдийн парк гэж хаана харяалагддаг нь ч мэдэгдэхгүй хүүхдийн баяр болохоор л нэг нээж хүүхдүүд тоглуулдаг газар байна, хүүхдийн паркыг хөгжүүлээд хүүхдүүд тоглох цуглах олноороо хөгжилдөх газар болговол ямар байна. Жил болгон 6 сарын нэгэн болохоор нөгөө хэдэн хуучин тоглоом дээр нэг өдөр хүүхдүүд нь баярлаад л өнгөрдөг өөр очиж тоглох газар ч ховор байна.	2024.10.17	Нийгмийн бодлогын хэлтэс	
5.	За тэгээд хамгийн чухал нь ажлын байр бий болгох байна даа. Хүн байгаа газарт хөгжил ирнэ. Аймаг, сумдад ялгаагүй ажлын байр л хэрэгтэй байна аа. Сумдыг хараад байхад төрийн байгууллагуудад нийт 100 орчим хүн ажиллаж, 10 орчим хувийн жижиг дэлгүүр, дугуй засвар, цайны газар /эд нар нь бас байнгын ажиллагаатай биш/-т 20- иод хүн ажиллан амьдралаа залгуулж үлдсэн нь малаа дагаж л ам тостож байна. Нэг сум нэг үйлдвэрлэл гэсэн бодол тээгдсээр л явдаг даа.	2024.10.17		
6.	Мөрийн хөтөлбөр болоод хэрэгжилтийг ил тод мэдээллэдэг системтэй болох хэрэгтэй. Мөрийн хөтөлбөр болоод ОНХС-аар хийгдэж байгаа ажлуудын явцыг зурган тайлантай танилцуулдаг дэлгэц, фэйж хуудас, АПП байвал иргэдийн хяналт, оролцоо нэмэгдэж, аймгийн өнгө төрх, амьдрах орчин, эдийн засаг, хөгжил бүтээн байгуулалтыг хурдасгах үр дүнтэй хэмээн бодож байна.	2024.10.17	ХБТХОХ	
7.	Энэ бүлэгтээ албан байгууллагуудын цахим хаягыг урьж оруулбал ажил хурдан явах боломж бүрдэх болов уу.	2024.10.17	ТЗУХ	
8.	С/ц сумын 7 -р баг 17-р байр буюу говийн тэнгэрийн байр халаалтын асуудал маш хүнд байна. Тухайн байр дулааны шугам сүлжээнд холбогдоогүй тул жил болгон айлууд нь энэ асуудалтай нүүр тулгардаг м2-н үнэ буюу монголд байхгүй үнээр тогтоолгож Дундговь ус суваг-с гуйж авдаг алдаг оног халааж	2024.10.17	ХБТХОХ Дундговь-Ус ААТОНӨҮГ	

	хэл ам хийхээр манайх халаах албагүй гэх мэтээр төвөгшөөж ханддаг энэ мэтээр тухайн байрны 50 айл халахгүй байсан дугарах эрхгүй жил бүр цаг хугацаанд нь халаалтаа ч авч үзээгүй хэдэн жил амьдарч байна. Энэхүү постыг анзаарч хараад бидэнд ямар гарц гаргалгаа шийдэл байна гэдэг дээр хариу өгвөл талархаад барашгүй юм.			
9.	Сумын төвийн хогийн цэгийг зэвэрдэггүй төмөр тороор хаших хэрэгтэй юм билээ. Зүүн урд тал тэр чигээрээ хог тархсан байна лээ.	2024.10.17	СЗД нар	
10.	1. Хог шатаах зуух, 2. Мак дэлгэрхангайгаас даац хэтрүүлж 90-100 тонноор тээвэр хийдэг үүнийг таслан зогсоож авто замаа бүтэн байлгах. Хөөтийн уурхайгаас чойр хүртэл мөн байгалийг сүйтгэж байна. Хулд Өлзийт цагаандэлгэрийн жоншны уурхайнууд мөн байгал сүйтгэж тээврээ хийж байна.	2024.10.17	ХБТХОХ Замын Цагдаагийн газар Авто тээврийн төв Мандалын Гэгээ Хот тохижуулах ААТОНӨҮГ	
11.	Дундговь аймагт нэн тэргүүнд 1. Цахилгаан станцаа ашиглалтанд оруулах асуудалд анхаарал хандуулах, 2. Одоо байгаа халаалтын компанийн асуудлыг шийдэхгүй бол өвөлдөө олигтой халдаггүй, хүйтэн, хүмүүсийн ажиллах орчин нөхцөл хүнд ялангуяа Холбоо, холбооны өмнөх засмал замаас зүүн тийш бүх албан байгууллагууд, аж ахуй нэгж, айл өрхүүд.	2024.10.17	ХБТХОХ	
12.	Иргэний хувиар саналаа нэмэрлэхэд: Аймгийн төв бол хөгжлийн тусгал байдаг. Дайраад өнгөрсөн хүн бүр аймгийн төвийн байдлыг хараад шууд аймгийг бүхэлд нь дүгнэдэг. Нэн даруй шийдэх асуудлууд: 1. Аймгийн төвийн гол замуудыг шинээр асфальтаар хучих. Аймгийн 70 жилээс хойш нэг ч хийгдээгүй ажил. Энэ зайлшгүй цаг нь болсон. 2. Үерийн усыг зайлуулах суваг шуудууг сайжруулах. Ингэхгүй бол хийсэн ажлыг баллаж, зам, талбайг шавар шавхайгаар дүүргэдэг гол юм бол үерийн ус. 3. Залуус хорооллын жишгээр шинэ хорооллын газрыг цэцэрлэг, сургуультай нь шийдвэрлэж, төсвийн хөрөнгөөр дулаан, цэвэр, бохир ус, цахилгааны дэд бүтцийг барьж байгуулах. Энэ ажил хийгдэхгүй бол хаа олдсон газраа орон сууцны барилга барьж байна.	2024.10.17	ХБТХОХ ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
13.	Дундговь аймгийн төв Мандалговь хот яг 2 дахь УБ одоо л газраа дахин төлөвлөхгүй бол оройтно. Миний хувьд аймаг болоод Мандалговь хотыг	2024.10.17		

	<p>удирдсан үе үеийн удирдлагуудад ад болтлоо үүнийг хэлсэн хэн нь ч тоож засаагүй. А зэрэглэлийн газрын бүх талбайгаа амины орон сууцны зориулалтаар олгочихсон. Тэд нар нь аймгийнхаа төвд амины орон сууцанд амьдарч байж гал түлж байвал яах уу? Төв, Хэнтий, Сүхбаатар, Өмнөговьд ийм айлууд нь тусдаа хороолол үүсгэж амьдардаг. Уг нь энэ газар дээр 5 ба түүнээс дээш давхар орон сууцнууд баригдсан бол илүү үзэмжтэй харагдана. Ер нь бол манай аймгийн орон сууцнууд халуун усгүйг би өөрөө байр авч амьдраад мэдсэн шдээ. Халуун устай болгох гээд одоо байгаа бүх трассаа дахиж ухаад замаа сэтлээд бүр сандайчина. Яая даа байз. Баригдсан байрнууд нь авто зогсоолгүй, авто зогсоолын тохижилт бүр байхгүй. Хорооллын доторх авто замаа Улсын төсвийн мөнгөөр хүртэл тавиулна, даварчихсан. Хүүхдийн тоглоомын талбайн талаар бодоогүй нь дээр биз, байх ч үгүй юм чинь бас ландшафт гэж мэддэг ч үгүй байх.</p>		ХБТХОХ ГХБХБГ	
14.	Хамгийн чухал асуудал чадварлаг боловсон хүчин. Хүнээ татахын тулд сумдад төрийн албан хаагчдын орон сууц барих. Шинээр ирж суурьшиж буй залуучуудаа оруулах гэх мэт.	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
15.	Ажил хэрэгч санал бодлоо солилцох ийм групп нээсэнд талархаж байна. Цөлжилтийн асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй байна."Тэрбум мод"-ны хүрээнд сумдад ямар ч төсөв мөнгө, шийдэл байхгүй байна. Өнгөрсөн жилүүдэд өөрсдийн боломжоороо мод суулгац тариалж ирсэн боловч цаашид хэрхэн арчилж ургуулах вэ? гэдэг асуудал тулгамдсан хэвээр байна.Учир нь ихэнх газар мэргэжлийн хүн хүч, цалин хөлсний асуудлаа шийдэж чадаагүй байгаад байна.	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
16.	Эхний ээлжинд аймгийн төвийн хогийн асуудлыг цэгцлэх, шинэ суурьшлын бүсэд цахилгааны шугам татах, аймгийн зүүн урд засмалын наад тал хуучин барилга трест орчмын балгас болсон газар, төвд байрлах халуун усны хуучин барилгын орчныг нэн түрүүнд цэвэрлэж шинэчлэх, төрийн албан хаагчдын хандлага, ёс зүйг сайжруулах, нийгмийн баталгааг хангах гээд тулгамдсан асуудлууд бнаа бна	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг ХБТХОХ	
17.	Аймаг сумдын албан байгууллага, өрх бүрээр мод тариулж ургалт нь 50.иас хувьтай ургасан модыг худалдан авах болон урамшуулах нь үргүй зардал хэмнэсэн цөлжилтийг эсрэг үр дүнтэй ажил болно гэж боддог доо	2024.10.17		
18.	2021 оны 3 сары 14-ны гамшгаар манай аймагт 10 хүн эндэж 280к мал хорогдоход дутагдалтай зүйл нь юу байсан бэ гэхээр мэдээлэл дутсан. Үүрэн телефоны операторууд аймаг, сумын төвд л 3G, 4G сүлжээ нэвтрүүлэхээс биш малчдад тохирсон сүлжээний өргөтгөл хийдэггүй. Манай аймагт малчдад анх гар утас бариулсан нь Жи мобайл гэхдээ одоо өргөтгөл хийгээгүй удснаас болж малчид Жи мобайлаар ярьж чадахаа байсан. Эрэл	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	

	суралд яваа хүн манай аймгийн нутагт бүх сүлжээний утастай явах шаардлага үүсдэг. Хүртээмжтэй сүлжээтэй оператор байхгүй. Ачааллаа даадаггүй жишээ нь Дэлгэрцогтын сумын 100 жилээр и-нет банк ажиллахгүй, карт уншихгүй, АТМ нь хоосон, утсаар хүнтэй ч ярьж болохгүй, зөвхөн бэлэн мөнгөөр худалдаа хийж байсан. Манай сумын 100 жил гээд инээдмийн киноны зураг авалтыг 100 жилийн хөгжил дэвшлээ дүгнээд наадчихсан Дэлгэрцогт суманд хийсэн ч байдаг			
19.	Би хилийн дээс алхахад хөрш улсууд ямар байдгийг мэдэхгүй л дээ, штамп даруулж үзсэн биш... гэхдээ 2008 оноос өнөөг хүртэл Монгол улсынхаа 10 аймгийн 160 гаруй сумдад ажиллаж, аялж, аж төрж үзсэн, явсан газраасаа үргэлж шинэ зүйлийг, шинэ санааг олж хардаг. Миний урьд нь очиж байсан аймаг, сумд одоо очиход төөрхөөр болтлоо өөрчлөгдсөн байдаг. Төв, Хэнтий 2-ыг жишээ татах байна. Тэнд сонгуулиар л улс төржилт болдог бусад үед орон нутгаа хөгжүүлдэг УИХ гишүүн, ИТХ 2 нь намчирхалгүй хоршиж ажилладаг учраас хөгждөг. Төсөв их багадаа биш. УБ-с зүүн тийш яваад үзээрэй Налайх, Эрдэнэ, Баяндэлгэр, Багануур, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Өмнөдэлгэр бүх сум суурин газрууд мал мах боловсруулах үйлдвэрүүдтэй Өмнөдэлгэр суманд бүр 3-н үйлдвэр байна. Тэдгээр үйлдвэрээс малын баас нь л хаягдал болж гардаг. Бусад бүх зүйлийг нь ангилж боловсруулж байна. Гэтэл манай аймагт үйлдвэр байтугай аятайхан бойны газар ч алга. Махны хэдэн ченжүүддээ базуулчихсан төрийн удирдлагатай аймаг. 2019 оны намар СЦ сумын малчдын хурал дээр би яг энэ асуудлыг дэвшүүлж байсан ч хэрэгжүүлээгүй. Баруун сумд Өвөрхангай аймаг руу зүүн сумд Говьсүмбэр аймгийн мал мах боловсруулах үйлдвэр лүү малаа тушаадаг. Бусад аймгийн төв рүү. Аймгийн бойнд орсон малын махыг нь л авдаг. Таван цул, дотор гэдэм, цус, толгой шийр, арьс бүгдийг нь ачиж аваачаад хог дээр хаядаг. Монголдоо гайхагддаг таана хөмүүлийн амттай махыг брэнд болгож чадахгүй хэдэн ченжүүддээ дарлагдсан аймаг. Үйлдвэр нь баригдчихвал тасралтгүй хангах нөөц нь тал дүүрэн бэлчиж байна, үйлдвэр нээгдвэл малчид дуртайяа малаа нийлүүлнэ. Ийм үйлдвэр нээгдээсэй	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
20.	Үйлдвэр байгуулна гэдэг маш хэцүү. Ноосны үйлдвэр ажилд оруулах гэж манай аймгийн хэдэн залуу олон жил маш их зүдэрсэн. Аймгийн дарга нэг уулзах байх. Ер нь хувийн хэвшлээс л санаачлага гарахгүй бол мөрийн хөтөлбөрт тусгаад хэрэгждэггүй. Харин УБ-Даланзадгад, Чойр-Арвайхээр гэсэн хоёр том замынхаа уулзвар дээр бүх төрлийн бараа материалын бөөний худалдааны томоохон төвлөрөл үүсгэх нөхцөл бүрдүүлж өгвөл олон хүн ажилтай болох нэг том боломж байж болох юм. Замын-Үүдээс Чойроор	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	

	дамжаад явж байгаа ачаа тээврийн урсгалыг аймгаараа дайруулж баруун аймгууд, Өмнөговь руу явуулах дамжлага бааз болж хөгжвөл илүү хурдан үр дүн гарна гэж боддог доо. Одоо хэрэгцээтэй бүхнээ УБ-аас л авдаг. Түгжрэл ихтэй учраас маш хүндрэлтэй, цаг их зарцуулж байна. Түүний тодорхой хэсгийг хангадаг агуулах сав сайтай, хямд төсөр тээвэр, ачих, буулгах техниктэй түргэн шуурхай үйлчилгээтэй ийм төвийг Дундговьдоо бодлогоор байгуулах хэрэгтэй.			
21.	Спорт заалны урд хэсгийн айл өрхүүд дулааны асуудал маш хүнд байнаа 1. халахгүй учир тэнь залгадаг төвийн халаалтанд холбогдсон гээд халаалтын мөнгө авдаг 2. бохир бөглөрдөг. янзлана гээд янзлаагүй 3. хогны асуудал маш хүд 4.хур тундасны дараа бүүр явалтгүй (шар шавар)	2024.10.17	ХБТХОХ Мандалын Гэгээ Хот тохижуулах ААТОНӨҮГ	
22.	Аймгийн хогийн цэгийг цэгцэлмээр санагддаг. Хогийн цэг нь аймагт ойрхон ядахнаа хашаалаад ч болтугай шийдэж чадахгүй аймгаас зүүн урагш 100 100 км хог нь хийссэн хогондоо хөглөрсөн аймаг болоод олон жил болж байна аа. Тэр замаар явахад үнэхээр ичмээр санагддаг шүү. Ядахаасаа хогноосоо салчхаад хөгжил ярихгүй бол. Энийг та анхааралдаа авч шийдэж өгч туслаарай. Цаг үеэ олсон, ард иргэдээ сонссон, асуудал шийдлээ ярилцсан зөв талбар болжээ.	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
23.	Аймаг орон нутгийн телевиз байгуулах сонирхолтой мэргэжлийн залуус хувийн хэвшлийг дэмжих мэргэжлийн хүмүүсийг бодлогоор сургаж бэлтгэх	2024.10.17	ТЗУХ	
24.	Аймагт хамгийн чухал асуудал бол хог хаягдал.Нэн тэргүүнд дахиврын төвийг байгуулж дахивруудыг төвлөрүүлдэг болох. 2-рт шатах хог хаягдлыг шатааж дулаан үйлдвэрлэдэг болох. 3-рт малын бууцыг бөөгнүүлж компас бордооны үйлдвэр барих. Энэ 3 асуудлыг шийдэж чадвал хог хаягдлыг 80% багасгана дээр нь хөрс сайжруулах асар бордооны нөөц болон асар их ажлын байрууд бий болно	2024.10.17	Мандалын Гэгээ Хот тохижуулах ААТОНӨҮГ	
25.	Хүүхдийн паркыг ажилд оруулж хүмүүсийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг орчинг бий болгомоор байна.	2024.10.17	НБХ	
26.	Энэ замыг ядаж засмал зам тавьдаггүй юм аа гэхэд хайрга асгаж янзлах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол бороо ороод буцаад шавар болоод ямар ч нэмэргүй.	2024.10.17	ХБТХОХ	
27.	Аймгийн төвийн золбин нохой, хогны асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй бна. Анхаарна уу	2024.10.17	СЦ сум, Мандалын Гэгээ Хот тохижуулах ААТОНӨҮГ	

28.	Аймгийн өнгө үзэмж гутаасан балгас болсон муухай барилга байгууламжаа хариуцсан эзэд нь байдаг бол буулгаж янзлаач ээ !!! ж нь; Хуучин халуун ус АН ын зүүн талын аймаар байшин Төвд байдаг хуучин өрхийн эмнэлэг Мандал зочид буудлын эсрэг талын байшин г.м	2024.10.18	ГХБХБГ	
29.	Аймгийн төвийн авто зам, замын байгууламжийг нэг сайн шинэчлэх шаардлагатай бна. Төв замыг өргөтгөж, мөн шаардлагатай замын сүлжээг шинээр төлөвлөх хэрэгтэй. Төв талбайг орчин үеийн шийдэлтэй тохижилтоор шинэчлэх, хавтанг нь солих. Мөн аймгийн орох хаалганаас төв рүү ортол чанартай гэрэлтүүлэг хийх /асдаг байх/.	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг ХБТХОХ	
30.	Өглөөний мэнд камержуулах нь эхний ээлжинд хэрэгтэй хийсэн болгоныг сүйтгэж хаядаг тэрнийг засаж янзлах гэж төсөв мөнгө их ордог өөрсдөөр нь янзлуулж хариуцлага тооцох хэрэгтэй	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
31.	Гадаадын иргэн аж ахуйн нэгж компанид ямар нэгэн хэлбэрээр газар олгохгүй байх зарчим баримталж ажилвал сайн байна.	2024.10.18	ГХБХБГ	
32.	Газрын тухайн хуулинд өөрчлөлт оруулмаар санагддаг. Газрын албанд танилтай эсвэл мөнгөтэй нь байршил сайтай газрыг аваад үнэ хүрэхийг нь хүлээдэг, түүгээр дэд бүтцийн ажил хийгдэхээр үнэлгээнд оруулж үнэгүй авсан газраа зарж ашиг олдог бус. Нэр дээрээ авсан 0.75 га газраа шууд хашаалаад тохиждог байх зохицуулалт хэрэгтэй байна. Яг юм хийе, хашаа байшин бариад амьдаръя гэхэд манай аймгийн төвд 5км радиуст иргэний өмчлөлд өгөх газар байхгүй. Яваад үзэхээр хатгасан хашаа байхгүй, битүү хоосон гэрчилгээ. Усгүй, тоггүй, замгүй хоосон нэр. Хашаагаа барьж тохижоогүй айлуудад хугацаатай албан тоот хүргүүлээд гэрчилгээг нь хүчингүй болгоод дахин төлөвлөлт хийгээд хашаагаа барих айлуудад шууд олгох хэрэгтэй. Харин төрөөс ус, цахилгааных нь шугамын асуудлыг шийдэх нь зүйтэй. Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Даланзадгад зэрэг сумд яг ингэж гэр хорооллоо төлөвлөж айл өрхүүдээ хашаажуулсан байдаг. Би 2018 онд ч билүү өмчлөлийн газар авсан чинь Нисэхээс баруун тийш, яг ийм хөгжлөөр манай аймаг хөгжвөл би лав тэнд гадас ч шаахгүй. Тус тусдаа өөрийн гэсэн хашаатай болоод гэрээ ч барина уу байшинд ч амьдарна уу хамаагүй өөрийн юмтай болоод төвхнө лдөө, насаараа айлын хашаанд амьдарч, нүхэн жорлон дүүргэсээр байтал өөртөө ч үрдээ ч юу ч үгүй л байна шдээ. Бэлчээрийн даац гэдэг шиг зарим айлын хашаа даац нь хэтэрсэн байдаг. Уг нь Монгол улс 1 хүнд ногдох газрын хэмжээгээр дэлхийд 1-т ордог ч эсрэгээрээ 1 хашаанд амьдрах айл хүнийхээ тоогоор бас тэргүүлэх гээд байна	2024.10.18	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг, ГХБХБГ	
33.	Сайнцагаан сум аймгийнхаа төв нь учир УБ хотоос, 15 сумаас иргэд ирж үнэ төлбөргүй газар авч суурьшлын бүс дотроосоо тэлж байна. Зам, барилга,	2024.10.18	ГХБХБГ	

	<p>шугам сүлжээний обектуудаар ахиад л дотроосоо идэгдэж байна. Төвдөө ойр учир малчид болон малын нягтаршил бас л ихэссээр. Ингээд л зовж байтал Луус, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Гурвансайхан сумд Хууль бусаар сумдын нутгийн заагийг өөрчлөн малчдаа Сайнцагаан сумын нутаг руу хүч түрүүлэн нутагшуулахын сацуу Сайнцагаан сумын үндсэн малчин айлуудыг шахаж, эрх зүйн мэдлэггүйг нь далимдуулж манай суманд шилжээд өвөлжөө хаваржааны бууцтайгаа үлд эсвэл нутаг чөлөөлж өг гэж дарамталдаг, газрын нэгдсэн сан дах цахим бүртгэлээс өвөлжөө хаваржааных нь газрын гэрчилгээг хүчингүй болгочихсон. За яахав түрүүлж байгуулагдсан Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумдад бол юм хэлэхгүй харин хамт байгуулагдсан Луус, Дэрэн, Гурвансайхан, Өлзийт сумд бол яршиг л байна. 1970 билүү 72 оны Ардын их хурлын депутатын хурлын шийдвэрээр тогтоож өгсөн хэмжээс одоо архивт байж л байна. Тэрийг орхиё гэхэд Нэгдэл тарахад газар нутаг хаагуур зааглаж байсныг мэдэх хүмүүс үхээд дуусаагүй шүү ялангуяа Дэрэн, Гурвансайхан сумдынхаа бага давраарай Сайнцагаан сумын мал малчин барагдаагүй шүү. Аль эсвэл Сайнцагаан сумын үе үеийн удирдлагууд Дэрэн, Гурвансайхан сумдад газар нутгаа зарсан юм уу? Энэ асуудлыг нэн түрүү шийдэхгүй бол өчнөөн малчид зэргэлдээ сумд руу шилжиж эсвэл зэргэлдээ сумдын малчид өвөлжөө, хаваржааных нь дэргэд зэрэгцүүлэн хороо бууц барьж байгаа нь маш их сөрөг нөлөө үзүүлж байна. Зөрчил, хэрүүл, дайсагнал, гэмт хэргийн ч эхлэл болдог. Энэ тал дээр Дэрэн, Гурвансайхан сумдын үе үеийн удирдлагууд эрс шийдэмгий хууль бус арга ажиллагаа явуулж байгааг Сайнцагаан сумын зааг нутгаар амьдардаг малчид тод томруун илэрхийлэх, гэрчлэх болно. Аймаг, сумын удирдлагууд болон Аймгийн газрын алба өнөөг хүртэл шийдвэртэй арга хэмжээ аваагүй. Уг нь сумдын хилийн заагийн маргааныг УИХ шийдвэрлэж батладаг атал Дэрэн, Гурвансайхан сумд шийдчихээд байдаг нь сонирхолтой. Үүний цаана маш том ашиг сонирхлын зөрчил бий гэж би харддаг...</p>			
34.	<p>A0201 авто замын 172-270км хүртэлх хэсгийн арчлалтыг хариуцдаг Дундговь Авто Зам Ххк-г ажлаа чанартай хийдэг болгomoор байна эсвэл өөр компаниар солих хэрэгтэй. 10 сарын эхээр засах гээд зүсээд авчихсан хэсгээ одоог хүртэл нөхөөгүй л байна. Гэтэл Тув Azza зүсч авлаа өдөрт нь нөхдөг, технологийн дагуу. Хурдан хүйтрээсэй гээд Дундговь Авто Зам Ххк залбираад сууж байгаа. Учир нь шар шавраар замын нүхээ бөглөөд хөлдөөчихнө. Хавар болтол асуудалгүй.</p>	2024.10.17	ХБТХОХ	
35.	<p>1.Арвайхээр-Мандалговь-Чойр(эсвэл Айраг) чиглэлийн авто замыг бариулж баруун болон Хангайн аймгуудын ачаа тээвэр ба зорчигчдын дайран өнгөрөх ачааллыг нэмэгдүүлэх, (зам дагасан хөгжлийн суурь тавигдана) Мөн зарим</p>	2024.10.18	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	

<p>нэг их дээд сургуулиудын иж бүрэн кампусийг байгуулж чадвал хүн амын төвлөрөл бий болох нэг шалтгаан бүрдэж болох юм.</p> <p>2. Аймгийн төвийн ус (газрын доорх усны нөөц хангалтгүй тохиолдолд магадгүй Онги голын хөндийгөөс цэвэр усны шугам татах хэрэгтэй. аймгаас 50км л зайтай байдаг. Онги голын ус хангалтгүй тохиолдолд Орхон голоос Онги голруу ус нийлүүлж болно), дулаан хангамжийн тооцоо судалгаанд үндэслээд, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг маш чамбай боловсруулах,</p> <p>3. Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу 1 ширхэг ч илүү шон барихгүйгээр орон сууцны барилгууд ба шугам сүлжээнд холбогдсон хаус хорооллын тоог нэмэгдүүлж, сургууль цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар Таван толгой, Оюу толгой, Овоот толгой болон бусад уурхайн ажилчдыг суурьшуулах замаар хүн амын тоог нэмэгдүүлэх, (хүн амын тоо нэмэгдсэнээр хүмүүс өөрсдөө ажлын байрыг нэмэгдүүлдэг)</p> <p>4. Хаус хорооллын төлөвлөлтийг заавал аймгийн төврүү шамбааралдуулж харахаас илүү Онги гол талруу буюу аймгийн төвийн баруун талруу тэлэх бодлогыг бариад тухайн орчинд дулааны шинэ станцыг байгуулж аймгийн төврүүгээ дулаанаа татвал зардал бага тусах ёстой. Хаус хорооллын газарт газар өмчилж авсан иргэн бүрт аймгаас шугам сүлжээг холбож өгдөг урамшуулал бий болговол нутгийн төдийгүй хотын хүмүүс газраа дуртай өмчилж авах болно.</p> <p>5. Ажиллаж буй уурхайнуудын нийгмийн хариуцлагын хүрээнд ногоон байгууламжийн сан бүрдүүлж, түүгээр аймгийн төвийг 10-15 жилийн дотор ногооруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй гэж бодож байна.</p> <p>6. Цөөн тооны барууны иргэдийг аймгийн төвд бодлогоор суурьшуулж, суурин амьдралын соёл болон өрхийн амьжиргааг хэрхэн бий болгох арга туршлагаудыг иргэдэд түгээж болно.</p> <p>7. Анхны хогийн цэггүй аймаг, анхны нүхэн жорлонгүй аймаг, анхны кофе болон эрдэнэшишийн үйлдвэрлэл хөгжүүлсэн аймаг... гээд гадны зээл тусламжууд, хөрөнгө оруулалтаар босдог олон сайхан боломжууд бий.</p> <p>8. Аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй тээврийн хэрэгсэл бүрээсээс хог хаягдлын хураамж заавал авдаг болгох хэрэгтэй. Энэ мөнгөөр хог хаягдлын менежментээ сайжруулах боломж бүрдэнэ.</p> <p>9. Төрийн албан хаагчдынхаа болон насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, ур чадварыг байнга сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгтэй. Аль ч газар төрийн алба хаагчид нь 100% нутгийн хүмүүс байгаа тохиолдолд тухайн газарт Алсын хараа гээч зүйл үгүй болдогийг мөн бодолцвол сайн. Энэ бүтэц Паретогийн зарчмаар 20:80-ын харьцаатай байвал зохимжтой.</p>		ГХБХБГ	
---	--	--------	--

36.	10 жилийн дотуур байрны хоолны чанар, хүртээмж орчин нөхцөлтэй танилцаарай шийдвэрлэх асуудал бий шүү.	2024.10.18	БШУГазар	
37.	1. Аялал жуулчлалын гол маршрутад орсон Цагаан суврагын орчныг сайжруулах хэрэгтэй гэж бодож байна. - тойруулж хашаалах - Орж гарах нэг л хэсэгтэй болгох - 00-н асуудлыг шийдвэрлэх - аюулгүй байдлыг хангасан шат хийх г.м	2024.10.17	СУАЖЗГазар, ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
38.	Зүүн хойд МТ клонкийн урд. Төмөрөөгийн колонкын хойно байдаг Хүрээлэнгийн зүүн хаалгыг авмаар байна. ҮЗЭГДЭХ ОРЧИН ХЯЗГААРЛАДАГ	2024.10.18	Санал	
39.	Та бээр хамгийн эхэнд хөрөнгө чинээ, цалин орлого, байр сав, машин тэрэг, зээл хууль авлага өглөг, үнэт эдлэл, өгцөө авцаагаа сайхан дэлгэрэнгүй танилцуулна уу. Үүнийг Дундговьчууд мэдэх эрхтэй бөгөөд 4 жилийн дараа ингэж тэгж идэж уулаа гэж хэлүүлэхгүйн тулд одоо танилцуулах нь зүйтэй байх гэж зөвлөх байна.... ХОЁРДУГААРТ: Төрийн алба шударга зарчимч, хуульд нийцсэн байх ба захирах захирагдах ёсыг “Төрийн албаны тухай хууль”-р зохицуулсан билээ. Гэвч суурь хүмүүжил, үзэл бодол, итгэл үнэмшлийн чиг хандлага нь үнэндээ таарахгүй бол эрхэм нөхдүүд өөрсдөө ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ эртхэн гаргах хэрэгтэй. Ширээ сандалтайгаа зууралдаад, үүрэг даалгаврыг биелүүлэхдээ назгай хойрго хандаж аймаг орны ажил, хөгжилд “тоормос” татах хэрэггүй юм. Энэ нь намчирхлыг гааруулж, нөгөөтэйгүүр багаар нь сонгоё, “баг бүрдүүлэх” гэдэг ойлголтыг намчдын тархинд гүнзгий суулгаж байгаа үндсэн шалтгаан мөн. ТАХ-чид Засаг даргынхаа мөрийн хөтөлбөр, бодлого зорилтыг биелүүлэхэд мэдлэг оюунаа харамгүй зориулах тангарагтай, ажлын алба нь билээ. Тиймээс Засаг дарга та ажлаа эхлэхдээ энэ шаардлагаа эртхэн тавьж, ам өчгөө өгч авалцаад, ойлголцоод эхлээрэй гэж зөвлөх байна. Ингэснээр “намчирхдаг” гэх яриаг таслан зогсоох учиртай... ГУТГААРТ: Үзэл баримтлал, итгэл үнэмшил, намын харъяалал өөр боловч нийгэмдээ маш хэрэгтэй хүмүүс олон байгаа. Тухайлбал миний аавын найз, ардчиллын алтан хараацай, ахмад сэтгүүлч Пүүжээ /С.Пүрэвсүрэн/ ах бол энэ ойлголтод хамрах хүн юм. Ийм хүмүүс сэтгэл зүрх, хөдөлмөр оюунаа хариуцсан ажилдаа бүрнээ зориулдаг юм шүү. Манай аймгийн сонин тасрахгүй гарсаар, хэвлэгдсээр, та бидний түүхийг бичсээр байгаа нь үнэлүүштэй гавъяа юм. Зөрүүдлээд, хэт намчирхаад үзэл бодол, хэл яриа тэс өөр байх боловч энэ мэт чадвар сэтгэлтэй хүнийг маш сайн дэмжиж, үйл ажиллагаандаа ашиглаарай гэж зөвлөмөөр байна. Чингис хаан ийм удирдах арга барил хэрэглэснээр агуу амжилтад хүрсэн билээ. Тухайн хүн нь өөрөө	2024.10.18	Санал	

	хүсэхгүй бол одоо яая гэхэв дээ... ДӨТГӨӨРТ: Таны өгсөн үүрэг даалгавар ил тод, хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан бүх хүнд нээлттэй, албан хаагчдад хариуцлага тооцсон байдал хууль зүйд нийцсэн бөгөөд аль нэг тал нь гомдолгүй, хүлээн зөвшөөрсөн байх учиртай гэдгийг дээд зэргээр анхаарч ажиллаарай гэж хүсэх байна...			
40.	Сайн байцгаана уу ах эгч нараа би жирийн нэг сурагч ч гэсэн энд үзэл бодлоо илэрхийлэх хэрэгтэй байх гэж бодлоо ☺ Эх орнынхоо ирээдүйд хэрэгтэй хүн болхын тулд бэлтгэгдэж байгаа миний хувьд төрсөн нутаг минь хөгжөөсөй гэсэн бодол бяцхан зүрхэндээ тээж явна.Залуу хүмүүс юм үзэж нүд тайлах хэрэгтэй гэдэг ч миний хувьд эсэргээрээ их сургуулиа төгсөөд нутагтаа амьдархыг хүсдэг.Дуу хуурын өлгий Дундговь гэж ярьдаг ч манай аймаг аймгийнхаа театрыг шинэчлээсэй гэж маш их хүсэж байна. жишээ нь Өмнөговь аймгийн театр нь маш гоё юм байна лээ зэргэлдээ аймаг маань маш хурдтай хөгжиж байгаатай адил манай аймаг хотын төвтөйгөө илүү ойрхон нь бас бидний давуу тал гэж бодож байна.Бас хүүхдийн паркийг анхааралдаа аваасай гэж хүсэх байна бяцхан дүү нар маань ч гэсэн тоглох эрхтэй гэтэл манай аймгийн хүүхдийн паркийн тоглоом жаахан чанаргүй жирийн нэг тоглоомууд байдаг хүүхдийн баяраар дүү нар минь ядаж тоглох орчин нь бүрдчихвэл, мөн гэр хорооллын гудамнуудын гэрэлтүүлэг муу байдаг, жаахан бүрий болоод гэрлүүгээ явахад гэрэлтүүлэг муу учир гудамжаар явахад жаахан айдастай байдаг. Дээрх бүх асуудлуудыг анхааралдаа аваасай гэж хүсэж байна.	2024.10.18	НБХ Мандалын Гэгээ Хот тохижуулах ААТОНӨҮГ	
41.	<ol style="list-style-type: none"> 1. Айл өрх болон албан байгууллагууд хогоо цэвэрлэх 2.Төвийн авто замын эвдрэлийг чанартай засах 3.Авто замын хурд сааруулагчийг стандартын дагуу болгох 4.Өвлийн улиралд орон сууцны халаалт муу байдаг 5.Хог, нохой, муурыг устгах 6. Дулааны цахилгаан станцыг ашиглалтад оруулж дуусгах 7.Сумын хогийн цэгийг цэгцлэх 8. Гудамжны гэрэлтүүлгийг бүрэн асаах 9. Хүүхдийн тоглоомын талбайг хамгаалах, тогтмол тордож, цэвэрлэх хүн ажиллуулах, хүүхдүүдийг хог хаяхгүй, тоглоомоо хайрлаж, гамтай байх соёлд сургах 10.Төвийн хуучин орон сууцны барилгыг шинэчлэх 11. Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах 12. Камержуулалтыг сайжруулах 13. Дугуйн зам, тэргэнцэртэй хүн, хүүхдийн тэрэг түрэх боломжтой саадгүй зам байгуулах. 	2024.10.18	-Сц сум -Замын цагдаагийн тасаг, Стандарт хэмжил зүйн хэлтэс -ХБТХОХ - Мандалын Гэгээ Хот тохижуулах ААТОНӨҮГ	

	14. Залуус хорооллын замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, зарим газраа явган хүний гарц байхгүй. Осол аваар гарах эрсдэл их өндөр байдаг.			
42.	Дундговь аймгийн Сайнцагаан сумын Тэвшийн говийн нүүрсний уурхайд хятадын хөрөнгө оруулалтай Монгол ажилчид байгаа юм уу? Үнэхээр баахан гадныхан ажиллаад байгаа юм уу? Малчид эсэргүүцээд байгаа юм уу гүү юм уу? Орон нутагт яг ямар ашигтай вэ? Ойр байгаа малчин өрхөд яг ямар ашигтай вэ? Тодорхой үнэн зөв мэдээлэл өгч иргэдэд тайлбар хийхгүй бол газар авах вэ?	2024.10.18	ХБТХОХ	
43.	Шуудайгаар зарж байгаа нүүрсний үнийг шалгаж өгөөч үнэ өндөр байна	2024.10.18	Санал	
44.	Хүүгийн маань санал: Мандал хороололын баруун засмалын хавьд хүүхдийн тоглоомын талбайтай болвол гоё. Бабаруу очиж л тоглодог. баба хол.	2024.10.19	ХБТХОХ	
45.	Театрын баруун талын барилга, спорт заалны баруун хойд барилгын газрыг хэн ДАРГА өгсөн бэ ? Барилга барихыг зүгээр гэж бодож байна уу хүмүүсээ ?	2024.10.19	ГХБХБГ	
46.	Говьд сайхан зун болсон.УБ чүүд угаасаа Дундговийн маханд дуртай.энэ чиглэлээр дорвитой юм хийгээрэй.	2024.10.19	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
47.	1.Төсөл хөтөлбөрийг ялангуяа хөнгөлөлттэй төслийг танил тал харж мэдээлэл дамжуулдаг, олгодогийг болиулмаар байна. Үнэхээр ирээдүйтэй ба олгох хүндээ хүрч очдоггүй. 2.Багийн дарга нараар дамжуулан хувиар гэрээр хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийхээ судалгааг гаргаж тэр хүмүүсээ дэмждэг баймаар байна. 3.мандалын 2ийн 8-аас 9 ин хоорондох зун бороо ороход хаашаа ч гарах аргагүй машин явган хүн явахад асар бэрхшээлтэй энэ гудмыг нэн яаралтай засаж янзалж өгөх боломж юу байнааа. Шороо гудмаар асгаад явна гэсэн .Манайд хүрээгүй бололтой.Хувь хүний хувиа хичээсэн байдлаас үүссэн энэ овоолог шороо захын айлуудыг олон жил үер усны аюулд хүргэх хэмжээнд хүрдэг т анхаарна уу	2024.10.18	ХХҮГ ХБТХОХ Сц сум, Мандалын Гэгээ Хот тохижуулах ААТОНӨҮГ	
48.	1. Хүнсний аюулгүй байдал- Худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа дэлгүүрүүд, хоолны газруудын авчирч зарж байгаа хүнс, ногоо, хийж зарж буй хоолонд хяналт шалгалт тавих хэрэгтэй. Хөгзөрч, муудсан жимснүүд, үс орсон хоол эдр бас их л харагдах юмдаа /Мэргэжлийн хяналт гэж байсандаа тэрэн шиг чиг үүрэгтэй алба ажлуулж, лангуун дээрх хүнснээс дээж авч шинжлэх/ 2. Зам тээвэр- УБ хотоос аймаг хүртэлх зам / хичнээн хүний амь нас, хөрөнгийг хохироож байна даа/ Дээр үеийн зам ангийг дахин байгуулж, хөндлөнгийн хяналтыг сайн тавьж, зам засахад ашиглаж байгаа материалд шалгуур гэж байдаг л байх тэрэнд нийцэж, бүрэн цутгалт хийж буйг бүрэн	2024.10.17	ХХААГ ХБТХОХ ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	

	<p>хянадаг байх Мөн аймгийн төвийн засмалыг сайжруулах, ганц нэг газар гарцын цагаан тэмдэглэгээ нэмэх / зарим газар арилсан л байна лээ/</p> <p>3. Үйлдвэр үйлчилгээ- Том үйлдвэр барих бол нэлээн удаан хугацааны асуудал тул хүлэмж, фермер, сүү, цагаан идээ, гар урлалыг дэмжсэн бодлого их хэрэгтэй санагдсан. Нутагт минь алим жимс, броккли, огурцы гээд тариалаад байгаа хөдөлмөрч иргэд их байнаа. Татварыг хөнгөлөх, худалдан борлуулах талбайг шийдэх гээд асуудлууд их л юм шиг байгаа юм.</p> <p>4. Дэд бүтэц, дулааны болон цахилгаан станц- 21 зуунд ингэж их тог тасардаг аймаг манайх л болуу даа. Гэмтэл их гардаг юм шигээ, энийг бодлогын түвшинд юмуу удирдах байгууллагад хүсэлт гарган хамтын шийдэлд хүрэх. Дулааны станцын баригдах үйл явцын хяналтыг сайжруулж, заасан хугацаанд ашиглалтанд авах. Мөн аймгийн төвийн хэдэн уурын зуухны үйл ажилагааг, идэвхижүүлэх, орон нутгийн хамтын гэрээг байгуулж, тодорхой хэмжээний шаардлагыг тавих. / Хөөрхий минь өвөл болохоор л хөлдөж, осгох шахсан хүмүүс байдаг шүү бид нар чинь, халаалтаа нэмье гэж хэлээд2 амжилтыг эс олдогдоо/</p> <p>5. Төрийн байгууллагын ажлын цагийг өглөө 8-с 17цаг хүртэл байвал зохимжтой юм шиг.</p> <p>6. Соёл амралтын хүрээлэн- Хуучин наадмын талбайг балгас хэвээр нь байлгаж байснаас тэр хэсгийг нэлэнхүйд нь амралтын хүрээлэн болгох.</p> <p>7. Иргэдтэйгээ уялдаа холбоотой засаглал- Хийж буй ажлаа иргэдэд мэдээллэдэг, аймаг орон нутгийн хөгжлийн талаар, болж бүтэхгүй зүйлсийн талаар иргэдийн хүсэлтийг авдаг, эдгээр ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх</p>			
49.	Иргэдийн ундны усны асуудалд анхаарах цаг болсон байх. Айлуудын крантаар үе үе зэвтэй ус гардаг учир усны төмөр хоолойг гуулин хоолойгоор солих ажлыг шат дараатайгаар хийвэл иргэдийн эрүүл мэндийг дэмжсэн чухал ажил болох байх...	2024.10.20	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
50.	Дундговь аймагт ил, далд олгогдсон лиценз, газар нутгаа ухаж, төнхөж байгаа асуудлыг сайн шалгаж. Ямар ямар дарга нар, яаж олгосон асуудлыг сөхөж учрыг нь олоорой гэж хэлмээр байна.	2024.10.17	Санал	
51.	Дундговь ус суваг халаалтаа олигтойхон өгчихөөч дээ Сонгуулийн өдөр янзын халсан тэрнээс хойш үлбийсэн л юм байна.	2024.10.20	Ду-Ус	
52.	Төвөөрөө мал бүр явуулахгүй байх хэрэгтэй тэжээлийн адуу үхэр ихтэй бна	2024.10.20	Сц сум	
53.	УБ-с 270 км хатуу хучилттай замаар холбогдсон мөртлөө манай аймагт өргөн хэрэглээний барааны үнэ хэт өндөр. Хувийн аж ахуй нэгж ашгийн төлөө ажиллах нь дамжиггүй. Гэхдээ ашгийн бус шуналын төлөө ажиллаад байна. Тэглээ гээд нэг сайхан төвлөрсөн зах, худалдааны төв гэж алга. Сохор	2024.10.17	ШӨХТын орон нутг дах байцаагч	

	номингийн бумбаа шиг баахан байшин, гадна орчны тохижилт байхгүй. Дотор орчны үзэмж байхгүй. Барааны үнээ нэмэхээс биш орчиндоо анхаарахгүй байж бас эрт онгойж орой хаахгүй. Төв орж юм аваад гарах гэхээр онгойхыг нь хүлээж үд өнгөрдөг. Хэрэглэгчид худалдан авалтаа хийдгээрээ хийж л байна гэвч аж ахуй нэгжүүд орчны тохижилт, үнийн хөөрөгдөл дээрээ анхаардаггүй.			
54.	Өмнөговьд уурхайд ажилладаг хүн байна аа. Манай аймгаар дайран өнгөрч байгаа ажлынхан маань үргэлж намайг үгээр идэж байна. Танай аймгийн хаалга махир труба байдаг л гэнэ. Оронгуутаа 2 гэр хорооллын дундуур явдаг л гэнэ. Баахан балгаснуудын хажуугаар явдаг л гэнэ. Энэ хэсэг газруудаа нэн түрүүнд дахин төлөвлөх хэрэгтэй байх аа.	2024.10.17	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
55.	Саяны 224,890,000 төгрөгөөр боловсрол, соёлын салбарын албан хэрэгцээнд нийлүүлдэг автобус арай бишээ. Нөгөө ногоон автобус шиг л харагдаад байх юм хаанаас ямар газар нийлүүлсэн юм бол гэхээр шилэн данснаасаа олдоггүй.	2024.10.21	ХБТХОХ	
56.	Сайнцагаан сумын 7-р баг Хангамжийн хажуу талын 7 давхар байранд халаалт өнөөг хүртэл ирээгүй, нялх хүүхэд, өндөр настан байгаа тул анхаарч өгнө үү!	2024.10.20	ХБТХОХ	
57.	Сургуулийн хүүхдүүдэд үйлчлэх автобус хүртээмжтэй байвал хүүхдүүд өглөө оройд харанхуйгаар холоос явгаар сургуульдаа явдаг байдал арилж хүүхдийг эрсдэлээс хамгаалах нэгэн хүчин зүйл болох талтай	2024.10.20	НБХ	
58.	2700 хүн амтай Хулд сум 2018 оноос Эмийн сангүй байгаа. Эмийн сан ажиллуулах хүсэлт, төслөө 6 сарын 1-нд өгчихсөн хүн байрныхаа түрээсийг төлөөд, хүлээгээд байна	2024.10.21	НБХ	
59.	Сайн Байна уу Луусын соёлын төвийн Дарга гэж тэтгэвэрийн авгай авчраад тэр хүн нь самараад дууссан байхаа, ажилчиддаа ялгаварлан тэнэг мангар гэнэ өмссөн зүүснээр өчнөөн гадуурхаж өөрт ашигтай хүмүүсээ гарийхаа доор ажиллуулж зүгээр үнэнийн хэлсэн хүмүүсээ ад үзэж, дураараа байгууллагын дотоод журамаа өөрчилөн тэрнийг нь хэлсэн хүнээ халаж идсэн уусан юмаа нууж нөгөө хүмүүсрүүгээ буруугаа чихэн тэр хүн нь бургусаа болж халагдсан гэж бүжгийн багштайгаа нийлж гадуур худлаа үнэн цуурхал тараан сонгуулийн үеээр намууд ирэж уулзалт хийнгүүт тэндээс нь мөнгө авч хувийн дансандаа хийж тэрнийгээ хоорондоо хуваан авсан удаа ч бий. Мөн даргыгаа эзгүйд дураараа гарын үсэг зурж цалин тавьж байсан удаа ч байна энэ бүгдийн илчлээд үнийн хэлхээр ад үзэж хавчиж гадуурхаж ажиллаас чөлөөлсөн байгаа. Ийм даргаа өөгшүүлэн ажиллуулсаар ирсэн байна. Ийм юмыг засаг захиргаа нь нууж хаана давраасаар байгаа нь	2024.10.19	Луус сум ЗД	

	хөөрхийлтэй. Одоо тэгээд эцэст өрөө зугтаад явсан сурагтай бна лээ. байгууллагынхаа юмыг зархийн зараад идэхийн идээд			
60.	СӨХ-н асуудал үнэхээр хүнд бнаа өөрөө дураараа гэнэт гарч ирчээд цэвэрлэгээ үйлчилгээ за тэр зан харилцааг нь хэлээд ч юу гэхэв арай даварцан хүн 1 бнаа иргэд мэднэ дээ	2024.10.20	Говь сервис СӨХ	
61.	Хөдөө аж ахуйн газар тариалан үйлдвэрлэл фэрмэрийн аж ахуйгаа дэмжин ажиллавал хөгжлийн нэг эх үүсвэр байх болов уу	2024.10.25	ХБТХОХ ХХААГ	
62.	Хогыг улиралд нэг ачих юм, өөрсдөө хүн амьтан унаа юм олж ачуулж байна. Хашаа гудамнуудынхаа хогийг тогтмол ачихгүйн бол гадуур албан байгууллагууд иргэд нийтийн цэвэрлэгээнд гараад яахын яг. Тэгснээ сар болгон бүх айлаас мөнгийг нь авч байгаа хот тохижуулах руу ярихаар ачиж байгаа гэж солиорно ачаад байгаа бол хүн яах гэж хэрүүл хийх гэж байгаа биш лавлах вэ эсвэл жолооч нар нь өөр халтуур хийгээд эсвэл энэ тэрүүгээр цаг алаад явжыдымуу дор бүрнээ ажлаа хиймээр байна өө	2024.10.26	Мандалын Гэгээ Хот тохижуулах ААТОНӨҮГ	
63.	Дундговь аймгийн Боржигон багийн урд байдаг сүрьеэгийн байр. Аймгийн бас нэг өнгө үзэмж дарж байгаа барилга. Цагтаа сайхан эмнэлэг байлаа. Дараа нь айлуудад хувьчилж өгсөн. Тэр үеийн аймгийн дарга нь 9 айлд хувьчилж өгсөн байдаг. Одоо энэ сүрьеэгийн байрыг аймаг нь аваад тэр 9 айлд нь зохих хэмжээний газрын төлбөрийн Олгоод Өөр сайхан махны зоорь ч юм уу тэжээлийн агуулах ч юм уу баримаар юм.	2024.10.27	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг	
64.	Шинээр баригдаж байгаа орон сууцны хорооллууд дотор цэцэрлэгтэй байх, эсвэл 1 давхартаа цэцэрлэгийн 1-2 бүлгийг зайлшгүй төлөвлөх шаардлага тавих, тэгэхгүй бол аймгийн төвийн 8 цэцэрлэг ачааллаа дийлэхээ болилоо, анги дүүргэлт 45-50 байгаа нь стандарт норм зөрчигдөж байна. Шинээр зүүн талд ариажихад, баруун талд мандалд цэцэрлэг төлөвлөх	2024.10.18	ХБТХОХ НБХ	
65.	1. Боржигон багийн Засаг дарга Угтахбаатар. Хувьдаа амины сууцтай, Политехникийн коллежийн баруун талд байртай, тэрийгээ түрээслүүлдэг. Хувьдаа машинтай, гэр бүлээрээ өндөр албан тушаал хашдаг хүнд яасан гэж байрны дэмжлэг үзүүлж байгаа юм бэ? 2. Анхбаярын аав Мөнхтөрийн хамаатан Саранзаяад байрны дэмжлэг үзүүлэх нь ашиг сонирхолын зөрчилтэй бишүү? 3. Сонгуулийн хороог улс төржүүлж, төрийн албаны нэрийг баастсан Түмэндэлгэрээс өөр эмчилгээний дэмжлэг авах албан хаагч аймагт алга уу? Сонгуулиар улс төржсөний шагнал юм биз дээ. Эд нарыг бүгдийг нь шалгаад акт тавих хэрэгтэй шүү!	2024.10.26	ТЗУХ	
66.	Улсын чанартай авто зам дагуу хог шороогоо иймэрхүү байдлаар асгамааргүй байна.	2024.10.28	ХБТХОХ	
67.	"Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр" гэсэн өнгөлөн далдалсан, өөрсдийнхөндөө өгсөн дэмжлэгт чинь ямар шалгуураар яаж хамрагддаг юм	2024.10.26	ТЗУХ	

	бэ?????????Хэн ч юу ч мэдээгүй , ямар ч сонгон шалгаруулалт юм зарлаагүй, сонсоогүй байхад л АН-ынхаа эрх баригчдын эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, найз нөхөддөө айргийн баяр нэртэй 10, 10 саяар нь өгсөн!!!!!! Ахиад л 10,10 саяар нь дарга сэтэртнүүдийн цүнх баригч, хөлс арчигч, хоол аягалагч, сонгуулийн ажлынхаа үнэнч зүтгэгч нартаа өгөөд байх юм аа!!!!!!!!!! Зарим дарга нар нь эхнэртээ өгүүлчихэж. Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр нэрээр хөдөлчих, хөлжчих юмаа!!!!!!!!!! АВЛИГА биш үү?			
68.	Яахаараа шөнөөр үндэсний хүнсний дэлгүүрүүд ажиллаж болдоггүй хэт хөөрөгдсөн үнэтэй гадны сүлжээ ажиллаад байдаг юм	2024.10.29	ХБТХОХ	
69.	Захын урд замыг зүүн тийш, хойд замыг нь баруун тийш 1 урсгалтай болгох саналтай бн	2024.10.29	ЗЦТасаг	
70.	Нохойгоо устгаачээ. Өглөө унтуулахгүй хуцаад. Өглөө, үдэш сүрэглэж хүүхэд айлгаад байх юм. Нохойн орон боллоо.	2024.10.27	СЦ сум	
71.	Шинээр бүтээн байгуулсан сайхан цэцэрлэгт хүрээлэндээ цэвэр сайхан, зөв боловсон, соёлтой байцгаая аа. Архины шил, тамхины иш, ахуйн хог хаягдлаа хаямааргүй байна шүү. Мөн хогийн саван доторх савыг хүртэл авсан байгаа нь арай л биш санагдсан. Бидний үр хүүхэд тоглож наадаж байгааг цаашид анхаармаар байна.	2024.11.02	Мандалын гэгээ ААТОНӨҮГ	
72.	Залуус хорооллын энэ хэсэгт хог маш ихээр цуглардаг газар байдаг. Тус газрын хогийг ойролцоох байрны оршин суугчид нийлж цэвэрлэсэн. Энэ газрыг ногоон байгууламжтай, ойр орчмын оршин суугчид гарч салхилдаг багахан сад болгочихвол сайхандаа.	2024.11.02	ХБТХОХ	
73.	Одоо сар бүр тогтмол нийтээрээ хог цэвэрлэж хэвших өдөртэй болох хэрэгтэй	2024.11.03	ХБТХОХ Мандалын гэгээ ААТОНӨҮГ	
74.	Дундговийн төвийн өнгө үзэмж гутаасан балгасууд эзэнтэй бол нурааж оронд нь сайхан барилга байгууламж барих талаар анхаармаар юм	2024.11.03	ГХБХБГазар	
75.	Одоо иргэдийн явдаг зорчдог хэсгийг хааж хорьж тавьсан хавтан чулуу цементүүдээ цэвэрлэмээр байна. Байшин болгоны буланд, хашаа болгоны буланд цемент чулуу! Ялангуяа нэн түрүүнд Нийгмийн даатгалын хэлтэс болон ойр орчмын байрнуудруу төвөөсөө орох замыг нь хаасан байгаа дугуйнууд!	2024.11.02	Мандалын гэгээ ААТОНӨҮГ	
76.	Залуус хороололын 101-р байр зогсоолоо нээгээчээ Бүхэл бүтэн энэ том зогсоол байхад хойд байрныхаа зогсоолд овоорчих юм. Энэ зураг дээр байгаа нь харин ч гайгүй байгаа нь. 23 цагаас хойш бол машин байтугай хүн ч зэрэх зайгүй болчихно. Оройн цагаар энд тэндээс дайвар өгөх авах, автобуснаас хүн тосох хүргэх ажил гараад л гарах гэхээр ямар ч гарах	2024.11.04	Говь сервис СӨХ	

	боломж зай завсар байхгүй, утасруу нь залгах гэхээр дугаар тавьсан машин байхгүй үнэхээр асуудалтай юм аа нээрээ. Хамгийн хэцүү нь хэн дуртай нь машин шүргэж мөргөчихөөд зугтана. Арай л биш ээ нээрээ. Энэ асуудлыг яаралтай шийдэж өгнө үү даргаа			
77.	Цоглог дэлгүүрийн баруун урд нилээн хэдэн жилийн өмнө баригдсан нийтийн бие засах газрыг ажилд оруулах. Хүний хамгийн наад захын хэрэглээ бие засах	2024.11.04	Сц сум	
78.	Их газрын чулуунд хийсэн энэ арга хэмжээ үнэхээр амжилттай сайн болсон. Жил бүр хийдэг аялал жуулчлалын Дундговийн брэнд болгож өргөжүүлмээр байна. Гадаад дотоодын жуулчид маш их очино. 8сард наадмууд дуусаад сулардаг сүүлийн 10хоногт хийдэг бол Гурвансайхан сум аймагт их орлого олох боломж шүү.	2024.11.02	ЗДҮАХ боловсруулах ажлын хэсэг, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	
79.	Энэ хогийн цэгийг хүнсний захууд холдуулмаар байх юм. Яг салхин дор нь хүнсний зах нэртэй гадаа талбайд мах сүү цагаан идээ, хүнсний ногоогоо ил задгай тавиад зарж байдаг. Ямар ч эрүүл ахуйн шаардлага хангахгүй харагддаг...	2024.11.05	ХХААГ, Мандалын гэгээ ААТОНӨҮГ	
80.	Дундговь-Ус ОНӨААТҮГ сантехникийн үйлчилгээний үнэ тарифаа нийтэд нээлттэй болгомоор байна. Далд хаалттай болгон хардлага дагуулаад байдгийг анхаармаар.	2024.11.05	Дундговь-Ус ОНӨААТҮГ	

Танилцсан: ЗДТГазрын дарга

Б.Лхагвабаатар

Тэмдэглэл хөтөлсөн: ТҮОНМ хариуцсан мэргэжилтэн

Г.Оюунтунгалаг